

Одоо үргэлжлэн байгаа цаг

The Present Continuous Tense

Үйл явдал дуусаагүй үргэлжилж байх нь энэ бүлгийн онцлог юм. Үргэлжлэх цагийн бүлгийг ерөнхийд нь томъёолбол:

To be +P1

Am

Is + P1 (verb+ing)

Are

Энэ цагийг мөн “progressive” гэж нэрлэдэг. Үйл үгийн үндсэнд “-ing” залгахад доорх бичлэгийн дүрмийг баримтлана.

- Үгийн эцсийн “e” гээгдэнэ. Жишээ нь: to take-taking
to write-writing to serve-serving
- Үгийн эцсийн дан гийгүүлэгчийн өмнөх богино эгшгийг хадгалахын тулд эцсийн гийгүүлэгчийг давхарлаж бичнэ.
Жишээ нь: to put-putting to run-running to swim-swimming
- “ie” эгшгийн нийлэмжээр төгссөн бол “ie” нь “y” болж хувирна. Жишээ нь: to tie-tying to lie-lying
- Бусад тохиолдолд + төгсгөлийг үйл үгэнд шууд залгаж бичнэ. Жишээ нь: to talk-talking to buy-buying
Монгол хэлнээ гол төлөв “-ж” байна хэмээн орчуулагддаг.

Энэ цагийг доорх тохиолдолд хэрэглэнэ.

1. Өгүүлэгч этгээдийн ярьж буй хоромтой давхцан үргэлжилж буй үйл явдлыг илэрхийлнэ.
I’m cooking dinner-Би оройн хоолоо хийж байна.
She is dancing at the moment-Тэр эмэгтэй одоо бүжиглэж байна.
2. “Одоо” цагтаа багтаж харьцангуй удаан хугацаанд үргэлжлэн буй үйл явдлыг илэрхийлнэ.
This week we are reading “Lady Anu” by B.Rinchen -Энэ долоо хоногт бид Б.Ринченгийн “Ану хатан” –г уншиж байна.

3. Ойрын ирээдүйд болох үйл явдлыг илэрхийлнэ. Энэ тохиолдолд ихэвчлэн хөдөлгөөн заасан үйл үгс хэрэглэгддэг.

I'm going to the Eastern aimag tomorrow-Би маргааш Дорнод аймаг руу явна.

4. Өөрчлөгдөн хувирсаар буй үйл явдлыг илэрхийлж болно.

The number of people without jobs is increasing-Ажилгүй хүмүүсийн тоо өсч байна.

5. Үйл явдал давтагдахад өөр нэг үйл явдал давхцан үргэлжилж болно.

I wear my glasses when I'm reading-Би уншиж байх үедээ нүдний шилээ зүүдэг.

6. Тэрчлэн уурлаж, уцаарлах байдлыг илэрхийлж болно. Энэ тохиолдолд:

Always-(ямагт)

Forever-(үүрд, үргэлж)

Constantly-(үргэлж, байнга)

Continuently-(байнга, тасралтгүй) зэрэг үгс хэрэглэгддэг.

The man next door is constantly drinking vodka and shouting loudly during the night-Хажуу айлын хүн байнга архи ууж, шөнийн турш чангаар хашгичих юм.

"Continuous"-т хувирдаггүй үгс

Хэсэг бүлэг үгс тухайлбал мэдрэхүй (sense) , ойлгоц (perception), оюуны үйл ажиллагаа(mental activity) зэргийг илэрхийлсэн үгс одоо үргэлжлэх цагт хувирдаггүй. Энэ тохиолдолд жирийн цагийг хэрэглэнэ. Жишээ нь:

Do you understand what he is speaking about?-Тэр юуны тухай ярьж байгааг чи ойлгож байна уу?

I like this bracelet-Энэ бугуйвч надад таалагдаж байна.

Do you remember at day?-Чи тэр өдрийг санаж байна уу?

Бодох сэтгэх гэсэн утгаар "think" гэдэг үг нь энэ цагт хувирч болно. Жишээ нь:

What are you thinking about?-Чи юуны тухай бодож байна вэ?

"Continuous"-т хувирдаггүй үгсийг жагсаавал:

to know-мэдэх

to want-хүсэх дурлах

to like-таашаах, дуртай байх, таалах
to wish-хүсэх дурлах ерөөх
to love-дурлах хайрлах хүсэх
to feel-мэдрэх, ухамсарлах, ойлгох, мэдэх
to see-харах, үзэх, ойлгох, ухаарах
to hear-сонсох
to seem-санагдах, бодогдох, үзэгдэх
to think-бодох, сэтгэх, санах
to realize-ойлгох, ухамсарлах, бүрэн төсөөлөх
to understand-ойлгох, мэдэх
remember-санах, дурсах
to forget-мартах, умартах
to recognize-таних, мэдэх
to believe-итгэх, найдах, бодох, таамаглах гэж үзэх
to mean-утгатай байх, бодох, санаатай байх
to suppose-таамаглах, бодох, үзэх
to hate-үзэн ядах, дургүй байх
to belong-хамаарах, харьяалагдах
to prefer-эрхэмлэх, илүүд үзэх
to need-хэрэгтэй болох, шаардагдах, хэрэг болох
to be-байх болох
to have-тай, тэй, той-байх, бий, байх

“to be ” “have to” үйл үгс нь үйлийг илэрхийлэх тохиолдолд “-ing” төгсгөл авч хувирна, өөрөөр хэлбэл үргэлжлэх цагийн бүлэгт хувирна. Жишээ нь:

They are having dinner-Тэд оройн хоолоо идэцгээж байна.

I’m being careful-Би болгоомжтой байгаа.

Тусгай асуулт:

What are you doing now?-Чи одоо юу хийж байна вэ?

I’m watching TV-Би зурагт үзэж байна.

What is your brother doing?-Ах чинь юу хийж байна вэ?

He is tanning a marmot skin-Тэр тарваганы арьс элдэж байна.

Ерөнхий асуулт:

Are you speaking Italian?-Чи Италиар ярьж байгаа юмуу?

Yes. I'm-Тийм ээ.

Is Tom sleeping?-Том унтаж байгаа юмуу?

No, he isn't. He is lying on the bed and watching TV-Үгүй ээ. Тэр орон дээрээ хэвтээд зурагт үзэж байгаа юм.

Ялгах асуулт:

Are you writing a composition or a letter?-Чи зохион бичлэг бичиж байгаа юмуу, захиа бичиж байгаа юмуу?

I'm writing a composition-Би зохион бичлэг бичиж байна.

Is he translating or copying the text?-Тэр сэдвийг орчуулж байгаа юмуу, хуулж байгаа юмуу?

He is translating it-Тэр үүнийг орчуулж байгаа юм.

Үгүйсгэх өгүүлбэр:

I'm not joking-Би тоглоогүй байна.

She isn't crying-Тэр эмэгтэй уйлаагүй байна.

Why aren't you writing?-Чи яагаад бичихгүй байна.

"To be going to"

Энэ хэллэг нь ойрын ирээдүйд болох гэж буй буюу хийхээр завдаж буй төлөвлөсөн үйл явдлыг илэрхийлдэг. "TO BE" гэсэн хэллэг нь бие ба цагаар хувирна. Жишээ нь:

Tomorrow we are going to leave for Moscow-Бид маргааш Москва руу явах гэж байгаа.

My brother is going to take an entrance examination the day after tomorrow-Дүү маань нөгөөдөр элсэлтийн шалгалт өгөх гэж байгаа.

Иймэрхүү өгүүлбэрийг одоо үргэлжлэн байгаа цагаар илэрхийлж болно. Жишээ нь:
I'm going to the concert to night.

Өнгөрөн үргэлжилсэн цаг

(The past continuous tense)

Өнгөрөн үргэлжилсэн цагийг ерөнхийд томъёолбол

Was
+ P1
Were

Монгол хэлнээ гол төлөв –ж байсан, байлаа гэх зэргээр орчуулдаг.

Энэ цагийг доорх тохиолдолд хэрэглэнэ.

- Өнгөрсөн тодорхой нэг цагт үргэлжилж байсан үйл явдлыг илэрхийлнэ.

Үүнд үйл явдлын эхлэл ба төгсгөл нь мэдэгдэхгүй буюу бүрэн дуусаагүй байдаг. Жишээ нь:

I was doing my homework at 9 o'clock yesterday evening-Өчигдөр орой 9 цагт гэрийн даалгавраа хийж байсан.

We were preparing for the examination at this time yesterday-Өчигдөр өдийд бид шалгалтандаа бэлтгэж байсан

- Нэг богино үйл явдал болж өнгөрөх тэр үед үргэлжилж байсан үйл явдлыг илэрхийлнэ. Энэ тохиолдолд цаг заасан байц гишүүн өгүүлбэр бүхий угсарсан нийлмэл өгүүлбэр хэрэглэгдэх бөгөөд тэрхүү гишүүн өгүүлбэр нь жирийн өнгөрсөн цагт байна. Жишээ нь:

When mother came in we were cooking dinner-Ээжийг орж ирэхэд бид оройн хоолоо хийцгээж байсан.

I was having a bath when the telephone rang-Утас дуугарахад би усанд орж байсан.

- Өнгөрсөн үйл явдлыг дүрслэн үзүүлэхдээ уг үйл явдлыг дараагийн үйл явдлуудын дэвсгэр болгон өгүүлэхэд хэрэглэдэг. Жишээ нь:

It was a dreadful evening. The snow was falling heavily, the wind was blowing and the trees were shaking strongly. A few people were hurrying somewhere, and the cars were skidding on the icy roads...-Айдас төрүүлсэн орой байлаа. Цас лавсан орж, салхи үлээн, модод хүчтэй найгаж байлаа. Цөөн хүн хаа нэгтээ яарч, машинууд мөс болсон зам дээр тоормослож байлаа...

- Өнгөрсөн цагт удаан алгуур болж байсан үйл явдлыг илэрхийлнэ. Жишээ нь:

The sun was rising-Нар мандаж байлаа.

She boiled some tea while the roast meat was cooling-Шарсан мах хөрж байх хооронд тэр эмэгтэй жаахан цай чаналаа.

- Хоёр буюу хэд хэдэн үйл явдал нэг зэрэг болж байсныг илэрхийлж болно.

Жишээ нь:

While I was talking to him mother was making tea- Намайг түүнтэй ярилцаж байх хооронд ээж, цай чанаж байв.

At this time yesterday we were staying at home and everybody was doing something-Өчигдөр өдийд бид гэртээ байж хүн бүр ямар нэгэн зүйл хийж байлаа.

- Мөн all day yesterday, all day long, the whole morning гэх мэт үгстэй хэрэглэгдэж болно. Жишээ нь:

They were playing on the riverside all day yesterday-Тэд өчигдөржингөө голын эрэг дээр тоглоцгоосон.

Тусгай асуулт:

What were you doing at 7:30 this morning?-Чи өнөө өглөө 7:30-д юу хийж байсан бэ?

I was having breakfast -Би өглөөнийхөө цайг ууж байсан.

What were you doing at this time yesterday?-Өчигдөр өдийд та нар юу хийцгээж байсан бэ?

We were working at the textile factory-Бид нэхмэлийн үйлдвэр дээр ажиллаж байсан.

Ерөнхий асуулт:

Were you going to the library at 3 o'clock afternoon?-Чи үдээс хойш 3 цагт номын сан руу явж байсан уу?

Yes, I was-Тиймээ.

Ялгах асуулт:

They were playing volleyball-Тэд волейбол тоглож байсан.

Were you studying in the library or were you cleaning the classroom at about 2 o'clock yesterday? -Өчигдөр хоёр цагийн үед чин номын санд хичээллэж байсан уу, ангиа цэвэрлэж байсануу?

I was studying in the library-Би номын санд хичээллэж байсан.

Үгүйсгэх өгүүлбэр:

We weren't drinking vodka when you knocked at the door -Чамайг хаалга тогших үед бид архи ууж байгаагүй.

I wasn't painting the door when Erdene came to see us-Эрдэнийг манайд ирэхэд би хаалгаа будаж байгаагүй.

Ирээдүйд үргэлжлэх цаг

(The Future Conitnuous Tense)

Ирээдүйд үргэлжлэх цагийг томъёолбол:

Shall
Be+P1
Will

Монгол хэлнээ ихэвчлэн –аад⁴ байж байх болно гэж орчуулдаг. Энэ цагийг доорх тохиолдолд хэрэглэнэ.

- Ирээдүйд тодорхой цагт үргэлжилж байх үйл явдлыг илэрхийлнэ.

We shall be taking our examination at this time tomorrow-Маргааш өдийд бид шалгалтаа өгөөд байж байх болно.

- Ирээдүйд нэг богино үйл явдал болж өнгөрөх үед үргэлжилж байх үйл явдлыг илэрхийлнэ.

When you come to see me tonight, I shall be translating your compositions-
Өнөө орой чамайг манайд ирэхэд би чиний зохион бичлэгүүдийг орчуулж байх болно.

- Тодорхой цаг хугацаагүй боловч ирээдүйд болох үргэлжлэх үйл явцыг өгүүлэхийг хүссэн тохиолдолд хэрэглэж болно.

Next Friday you will be flying to America-Ирэх баасан гаригт чи Америк руу нисээд явж байх юм байна.

Тусгай асуулт:

What will your brother be doing 6 o'clock tomorrow-Танай ах маргааш 6 цагт юу хийж байх вэ?

Who will be working in the garden when I get there-Намайг очиход цэцэрлэгт хэн ажиллаж байх вэ?

Ерөнхий асуулт:

Will you be sleeping if I come to your place early in the morning?-Хэрэв би танайд өглөө эрт очвол чи унтаж байхуу?

Yes, I will be-Тийм ээ. Би унтаж байна.

Ялгах асуулт:

Will Tom or John be working here at 5 o'clock this afternoon?-Үдээс хойж 5 цагт энд Том ажиллаж байхуу, Жон ажиллаж байхуу?

Үгүйсгэх өгүүлбэр:

I shall not be staying home when he phones me tonight-Өнөө орой түүнийг над руу утасдахад би гэртээ байхгүй байна.

Одоо төгссөн цаг

Present Perfect Tense

Төгсөх цагийн бүлгийн хамгийн гол ерөнхий шинж нь үйл явдлын үр дүн байдаг. Энэ бүлгийн ерөнхий томъёо нь:

To have+ PII

Энэ бүлэг нь өгүүлэгч этгээдийн ярьж буй хормоос өмнө болох үйл явдлыг илэрхийлдэг. Одоо төгссөн цагийг томъёолбол:

Have
+ PII
has

Энэ цагийг доорх тохиолдолд хэрэглэдэг.

➤ Дөнгөж сая болж өнгөрсөн үйл явдлыг илэрхийлнэ. Жишээ нь :

We have finished the work-Бид ажлаа дуусчихлаа.

- Үйл явдлын үр дүнг илэрхийлнэ. So far-одоогоор, одоогийн байдлаар гэсэн үгийг хэрэглэж болно. Жишээ нь:
Bayar has learned about two thousand English words so far-Баяр одоогийн байдлаар 2000 орчим англи үгс цээжлээд байна.
- Аль эрт эхэлсэн боловч одоо хүртэл үргэлжилж буй явдлыг илэрхийлнэ. Энэ тохиолдолд “since” угтварыг хэрэглэнэ. Жишээ нь:
We have lived in Ulaanbaatar since 1960-Бид Улаанбаатарт 1960 оноос хойш амьдарч байна.
Энэхүү үйл явдал үргэлжлэх хугацааг +угтварын тусламжтайгаар илэрхийлж болно. Жишээ нь:
We have lived in Ulaanbaatar for 37 years-Бид Улаанбаатарт 37 жил амьдраад байна.
- Үйл явдлын үр дүнг илэрхийлэхдээ ямар үйл явдал болсноос хойш болсныг тодорхойлон хэлж болно. Энэ тохиолдолд цаг заасан гишүүн өгүүлбэр бүхий угсарсан нийлмэл өгүүлбэр хэрэглэгдэх бөгөөд гишүүн өгүүлбэр нь жирийн одоо цаг дээр байна. Жишээ нь:
They have built 3 big houses since the came here-Тэд энд ирснээсээ хойш 3 том байшин бариад байгаа юм.
- Тэрчлэн today, this morning/afternoon/ evening/ week/ month/ year/ semester/ season зэрэг үгстэй хамт хэрэглэгдэж үйл явдлын үр дүнг заана. Ингэхдээ зөвхөн тухайн цаг хугацаандаа багтаж ярих тохиолдолд одоо төгссөн цаг хэрэглэгдэнэ. Жишээлбэл: “This morning” гэсэн хэллэгийг хэрэглэхдээ өгүүлэгч этгээд өдрийн 12 цагаас дотогш ярьж байвал одоо төгссөн цагийг , 12 цагаас хойш ярих тохиолдолд жирийн өнгөрсөн цагийг хэрэглэнэ.
This month we have read two english books-Энэ сард бид хоёр англи ном уншаад байна.

- Ever-хэзээ нэгэн цагт ,Never-хэзээ ч үгүй гэсэн цаг заасан үйл хавсралтай хэрэглэгдэж хүн амьдралдаа ямар нэгэн зүйлийг хийж үзсэн эсэх тухай өгүүлдэг.

Have you ever ridden a horse?-Чи морь унаж үзсэн үү?

No, I haven't. I have never ridden a horse-Үгүй ээ. Би хэзээ ч морь унаж байгаагүй.

To have been, to have gone гэсэн хоёр хэллэг хоорондоо утгын ялгаатай. "To have gone"-хэллэгийг аль нэгэн тийш явчихаад ирээгүй юмуу эсвэл замдаа явж байх тохиолдолд хэрэглэдэг бол "To have been" хэллэг аль нэг тийш явсан боловч эргээд ирсэн байх тохиолдолд хэрэглэгдэнэ. Жишээ нь:

He has gone to London-Тэр Лондон руу явчихсан.

He has been to London-Тэр Лондон руу яваад ирсэн.

- Амьдралдаа анх удаа ямар нэгэн зүйлийг хийж үзэхэд хэрэглэнэ.
It is the first time I have ever driven a car-Би амьдралдаа анх удаагаа машин барьж үзэж байна.
- Хавсрал нэрийн давуу зэрэгтэй хэрэглэнэ.
This is the most interesting film I have ever seen -Энэ бол миний үзэж байсан кинонуудаас хамгийн сонирхолтой нь байна.
- Always-ямагт, just-дөнгөж сая, already-аль хэдийн, recently-саяхан, often-голдүү, lately-сүүлийн үед ,yet -хараахан зэрэг үгстэй хамт хэрэглэдэг
We have always lived here-Бид ямагт энд амьдарсаар ирсэн.
We have often come here-Бид байнга энд ирж байна.
"yet"-хэмээх үйл хавсрал нь одоо төгссөн цагт ихэвчлэн үгүйсгэх өгүүлбэрт хэрэглэгдэнэ.
"yet"-нь туслах үйл үгээс хойш байж болно.
I haven't yet read this book-Би намайг уншаагүй л байна.
Perfect Continuous(Төгсөн үргэлжлэх бүлэгт) хэрэглэгддэггүй үгс
Perfect(Төгссөн) цагийн бүлэгт хэрэглэнэ.
I have known him since last year -Би түүнийг өнгөрсөн жилээс хойш мэдэх юм.

Тусгай асуулт:

Төгссөн цагийн бүлгийн гол асуулт бол How many? How much? юм.

How many english books have you read?-Чи хичнээн англи ном уншаад байгаа вэ?

What problems have you solved?-Та нар ямар ямар асуудлуудыг шийдвэрлээд байгаа вэ?

Ерөнхий асуулт:

Have you translate your text ?-Чи текстээ орчуулчихсан уу?

Yes, I have-Тиймээ.

Ялгах асуулт:

Have you lost your watch or your key?-Чи цагаа гээчихсэн юмуу, түлхүүрээ гээчихсэн юмуу?

Үгүйсгэх өгүүлбэр:

I haven't seen Bayar since last week-Би Баярыг өнгөрсөн долоо хоногоос хойш харсангүй.

Өнгөрөн төгссөн цаг

The Past Perfect Tense

Өнгөрөн төгссөн цагийг томъёогоор үзүүлбэл:

Had+ PII

Энэ цагийг доорх тохиолдолд хэрэглэнэ.

- Тодорхой нэг цаг, мөч(өдөр, сар, жил, зуун)гэхэд болж өнгөрчихөөд байсан үйл явдлыг илэрхийлнэ.Цаг хугацаа заасан үгийн өмнө “by” угтвар үг хэрэглэнэ.

They had finished their work by 6 o'clock-6 цаг гэхэд тэд ажлаа дуусчихсан байсан.

- Нэг богино үйл явдал болж өнгөрөхөд түүнээс өмнө болчихоод байсан үйл явдлыг илэрхийлнэ. Энэ тохиолдолд цаг заасан байц гишүүн өгүүлбэр бүхий угсарсан нийлмэл өгүүлбэр хэрэглэгдэх бөгөөд гол өгүүлбэр нь өнгөрөн

төгссөн цагт гишүүн өгүүлбэр нь жирийн өнгөрсөн цагт байна. Гишүүн өгүүлбэр гол өгүүлбэртэйгээ ихэвчлэн “when” гэсэн холбоосоор холбогдоно.

When I got to the station, the train had left-Намайг галт тэрэгний буудал дээд хүрч очиход галт тэрэг явчихсан байлаа.

Дүрэм ёсоор гишүүн өгүүлбэр нь гол өгүүлбэрийн өмнө ба хойно аль ч байрлалд байна. Гол өгүүлбэрийн араас гишүүн өгүүлбэрээр эхэлбэл гол өгүүлбэрээс нь таслалаар зааглана.

All the people had slept when I came-Намайг ирэхэд бүх хүмүүс унтчихсан байсан

- Хоёр үйл явдал дараалан болж өнгөрөхөд эхний үйл явдлыг өнгөрөн төгссөн цагаар дараагийн үйл явдлыг жирийн өнгөрсөн цагаар илэрхийлнэ. Энэ тохиолдолд үйл явдлын дэс дараа чухал байдаг.

He had opened the window before he switched on the TV- Тэр зурагтаа асаахаасаа өмнө цонхоо нээв.

Before холбоосын оронд “then”, “after”, “as soon as” холбоосуудыг хэрэглэж болно. Үүнд then холбоосыг before холбоосын оронд шууд орлуулж болно. Харин after, as soon as холбоосуудыг хэрэглэхэд байр нь солигдоно. Хэрэв үйл явдал дуусмагц дараагийн үйл явдал маш хоромхон зуур залган өнгөрвөл гол ба гишүүн өгүүлбэрт аль алинд нь жирийн өнгөрсөн цагийг хэрэглэнэ.

As soon as she had received a letter, she replied to it-Тэр эмэгтэй захиаг хүлээж авсан даруйдаа л хариуг нь бичсэн.

- Нэг үйл явдал болоход түүнээс өмнө уг явдал болж байгаагүй болохыг илэрхийлнэ.

Last month we flew to Spain. My uncle was very nervous because he had never flown on a plane before-Өнгөрсөн сард бид Испани руу ниссэн юм. Авга ах маань урьд нь онгоцоор нисч байгаагүй тул сэтгэл нь тун их хөдөлж байв.

- Өнгөрөн төгссөн цагтай хамт always-ямагт, for several days-хэдэн өдрийн турш гэх мэт хэллэг хэрэглэгдэж нэг үйл явдал болж эхлээд уг үйл явдлыг хүртэл үргэлжилсэн болохыг илэрхийлж болно.

He had always wanted to visit India, so his father took him there last summer-Тэрээр Энэтхэг явахыг ямагт хүсдэг байсан тул өнгөрсөн зун аав нь түүнийг тийш нь авч явжээ.

- Одоо төгссөн цагт хэрэглэгддэг just, already зэрэг үгс мөн өнгөрөн төгссөн цагт хэрэглэгдэнэ.

I had just got up when Bayar phoned-Баярыг утасдахад би дөнгөж босоод байсан.

- Үйл явдал ямар нэг тодорхой хугацаа хүртэл болж амжаагүй буюу эсвэл нэг үйл явдал болж өнгөрөхөд өөр нэг үйл явдал болж амжаагүй болохыг илэрхийлж болно. Энэ тохиолдолд үгүйсгэх өгүүлбэр хэрэглэгдэнэ.

They hadn't reached the place at 6 o'clock-Тэд очих газраа 6 цагт хүрч амжсангүй.

- Шууд хэлсэн үгийг хожим дам маягтай ярихад шууд үг нь жирийн өнгөрсөн цагт юмуу одоо төгссөн цагт байвал дам ярианд өнгөрөн төгссөн цагийг хэрэглэнэ.

My granddad said that he had known your granddad since his childhood-Манай өвөө танай өвөөг хар багаасаа л мэднэ гэж байна билээ.

Асуух өгүүлбэр:

By what time? When? Where? зэрэг асуултууд голдуу хэрэглэгдэнэ.

By what time had they finished their work?-Тэд ажлаа хэдэн цаг гэхэд дуусчихсан байсан бэ?

Where had you studied before you entered the Institute?-Чи дээд сургуульд орохоосоо өмнө хаана сурдаг байсан бэ?

Үгүйсгэх өгүүлбэр:

He hadn't said any word when she got on the bus-Тэр эмэгтэйг автобусанд ороход нь тэрээр үг дуугарч амжсангүй.

Ирээдүйд төгсөх цаг

The Future Perfect Tense

Ирээдүйд төгсөх цагийг томъёолбол:

Shall
Have+ PII
Will

Ирээдүйд төгсөх цагийг доорх тохиолдолд хэрэглэнэ.

- Ирээдүйд тодорхой нэг цаг, хугацаа гэхэд болж өнгөрчхөөд байх үйл явдлыг илэрхийлнэ.

The children will have come back from the circus by 6 o'clock-Хүүхдүүд 6 цаг гэхэд циркээс эргээд ирчихнэ.

- Ирээдүйд нэг үйл явдал болоход түүнээс өмнө болж өнгөрчхөөд байх үйл явдлыг илэрхийлнэ. Энд цаг заасан гишүүн өгүүлбэр бүхий угсарсан нийлмэл өгүүлбэр хэрэглэгдэх бөгөөд гишүүн өгүүлбэр нь жирийн одоо цагт байна.

I shall have translated these texts when you come back-Чамайг эргээд ирэхэд би эдгээр сэдвүүдийг орчуулчихаад байж байх болно.

Ирээдүйд төгсөх цагт to finish-гүйцээх, to complete-зэрэг үгс нэлээд их хэрэглэгддэг

- Цаг ба нөхцөл заасан гишүүн өгүүлбэр ирээдүйд төгсөх цагийн утгыг заахад одоо төгссөн цагт хэрэглэгдэнэ.

I'll go out after I have cleaned my room-Би өрөөгөө цэвэрлэчихээд гадагшаа гарна.

Асуух өгүүлбэр:

Ирээдүйд төгсөх цагт туслах үйл үг нь “shall”, “will” байдаг тул өгүүлэгдэхүүний өмнө зөвхөн эдгээр туслах үгийн аль нэг байх бөгөөд have нь үйл үгийнхээ өмнө байрлана.

By what time will you have come back from the library?-Чи хэдэн цаг гэхэд номын сангаас эргээд ирчихсэн байх вэ?

Үгүйсгэх өгүүлбэр:

The meeting will not have begun yet when you come back-Чамайг эргээд ирэхэд хурал эхлээгүй л байж байх болно.

Өнгөрөн төгссөн цаг

The Past Perfect Tense

Өнгөрөн төгссөн цагийг томъёогоор үзүүлбэл:

Had+ PII

Энэ цагийг доорх тохиолдолд хэрэглэнэ.

- Тодорхой нэг цаг, мөч(өдөр, сар, жил, зүүн)гэхэд болж өнгөрчихөөд байсан үйл явдлыг илэрхийлнэ.Цаг хугацаа заасан үгийн өмнө “by” угтвар үг хэрэглэнэ.
They had finished their work by 6 o'clock-6 цаг гэхэд тэд ажлаа дуусчихсан байсан.
- Нэг богино үйл явдал болж өнгөрөхөд түүнээс өмнө болчихоод байсан үйл явдлыг илэрхийлнэ. Энэ тохиолдолд цаг заасан байц гишүүн өгүүлбэр бүхий угсарсан нийлмэл өгүүлбэр хэрэглэгдэх бөгөөд гол өгүүлбэр нь өнгөрөн төгссөн цагт гишүүн өгүүлбэр нь жирийн өнгөрсөн цагт байна. Гишүүн өгүүлбэр гол өгүүлбэртэйгээ ихэвчлэн “when” гэсэн холбоосоор холбогдоно.

When I got to the station, the train had left-Намайг галт тэрэгний буудал дээд хүрч очиход галт тэрэг явчихсан байлаа.

Дүрэм ёсоор гишүүн өгүүлбэр нь гол өгүүлбэрийн өмнө ба хойно аль ч байрлалд байна. Гол өгүүлбэрийн араас гишүүн өгүүлбэрээр эхэлбэл гол өгүүлбэрээс нь таслалаар зааглана.

All the people had slept when I came-Намайг ирэхэд бүх хүмүүс унтчихсан байсан

- Хоёр үйл явдал дараалан болж өнгөрөхөд эхний үйл явдлыг өнгөрөн төгссөн цагаар дараагийн үйл явдлыг жирийн өнгөрсөн цагаар илэрхийлнэ. Энэ тохиолдолд үйл явдлын дэс дараа чухал байдаг.

He had opened the window before he switched on the TV- Тэр зурагтаа асаахаасаа өмнө цонхоо нээв.

Before холбоосын оронд “then”, “after”, “as soon as” холбоосуудыг хэрэглэж болно. Үүнд then холбоосыг before холбоосын оронд шууд орлуулж болно. Харин after, as soon as холбоосуудыг хэрэглэхэд байр нь солигдоно. Хэрэв үйл явдал дуусмагц дараагийн үйл явдал маш хоромхон зуур залган өнгөрвөл гол ба гишүүн өгүүлбэрт аль алинд нь жирийн өнгөрсөн цагийг хэрэглэнэ.

As soon as she had received a letter, she replied to it-Тэр эмэгтэй захиаг хүлээж авсан даруйдаа л хариуг нь бичсэн.

- Нэг үйл явдал болоход түүнээс өмнө уг явдал болж байгаагүй болохыг илэрхийлнэ.

Last month we flew to Spain. My uncle was very nervous because he had never flown on a plane before-Өнгөрсөн сард бид Испани руу ниссэн юм. Авга ах маань урьд нь онгоцоор нисч байгаагүй тул сэтгэл нь тун их хөдөлж байв.

- Өнгөрөн төгссөн цагтай хамт always-ямагт, for several days-хэдэн өдрийн түрш гэх мэт хэллэг хэрэглэгдэж нэг үйл явдал болж эхлээд уг үйл явдлыг хүртэл үргэлжилсэн болохыг илэрхийлж болно.

He had always wanted to visit India, so his father took him there last summer-
Тэрээр Энэтхэг явахыг ямагт хүсдэг байсан тул өнгөрсөн зун аав нь түүнийг
тийш нь авч явжээ.

- Одоо төгссөн цагт хэрэглэгддэг just, already зэрэг үгс мөн өнгөрөн төгссөн цагт хэрэглэгдэнэ.

I had just got up when Bayar phoned-Баярыг утасдахад би дөнгөж босоод
байсан.

- Үйл явдал ямар нэг тодорхой хугацаа хүртэл болж амжаагүй буюу эсвэл нэг үйл явдал болж өнгөрөхөд өөр нэг үйл явдал болж амжаагүй болохыг илэрхийлж болно. Энэ тохиолдолд үгүйсгэх өгүүлбэр хэрэглэгдэнэ.

They hadn't reached the place at 6 o'clock-Тэд очих газраа 6 цагт хүрч
амжсангүй.

- Шууд хэлсэн үгийг хожим дам маягтай ярихад шууд үг нь жирийн өнгөрсөн цагт юмуу одоо төгссөн цагт байвал дам ярианд өнгөрөн төгссөн цагийг хэрэглэнэ.

My granddad said that he had known your granddad since his childhood-Манай
өвөөг танай өвөөг хар багаас нь мэдэж гэж байна билээ.

Асуух өгүүлбэр:

By what time? When? Where? Зэрэг асуултууд голдуу хэрэглэгдэнэ.

By what time had they finished their work?-Тэд ажлаа хэдэн цаг гэхэд дуусчихсан
байсан бэ?

Where had you studied before you entered the institute?- Чи дээд сургуульд
орохоосоо өмнө хаана сурдаг байсан бэ?

Үгүйсгэх өгүүлбэр:

He hadn't said any word when she got on the bus-Тэр эмэгтэйг автобусанд ороход нь
тэрээр үг дуугарч амжсангүй

Одоо төгсөн үргэлжлэх цаг

The Present Perfect Continuous Tense

Төгсөн үргэлжлэх цагийн бүлэг нь үйл явдлын үргэлжлэх хугацааг заах ба нөгөөтэйгүүр үйл явдал тасралтгүй үргэлжилсээр байх санааг илэрхийлдэг. Төгсөн үргэлжлэх цагийн бүлгийг ерөнхийд нь томъёолбол:

To have+been+PI

Үүнээс одоо төгсөн үргэлжлэх цагийн томъёог үүсгэвэл:

Have
+been+PI
Has

Одоо төгсөн үргэлжлэх цаг дараах тохиолдолд хэрэглэгдэнэ.

- Өгүүлэгч этгээдийн ярьж буй үеэс өмнө эхэлсэн үйл явдал үргэлжилсээр ярьж буй үеийг хүртэл болон цаашид ч мөн үргэлжилсээр байж болох санааг илэрхийлнэ. Үүнийг монгол хэлнээ -саар⁴ нөхцөлөөр орчуулдаг.

It has been raining outside-Гадаа бороо орсоор л байна.

- Тухайн үргэлжилсээр буй үйл явдал хэдийд эхэлсэн болохыг, тэрчлэн хэдий хэр хугацаанд үргэлжлээд байгаа болохыг заана. Үүнд "since", "for" угтварууд хэрэглэгдэнэ.

I have been learning English for 2 years-Би англи хэлийг 2 жил үзээд байна.

- Үйл явдал өгүүлэгч этгээдийн ярьж буй үе хүртэл үргэлжлээд төгсч болно.
There you are! I have been waiting for you for an hour and a half-Та нэг ирэв үү,
би таныг цаг 30 минут хүлээлээ
- Өнгөрсөн аль нэг цагт эхлээд харьцангуй удаан хугацаанд үргэлжилж
байгаад өгүүлэгч этгээдийн ярьж буй үеэс өмнөхөн зогссон үйл явдлыг
илэрхийлж болох ба дүрэм ёсоор тодорхой хугацаанд үргэлжлэх боломж
бүхий үйл үгс энд хэрэглэгдэнэ.
Bob is coming tired. He has been working hard-Боб ядарчихсан ирж байна. Тэр
шаргуу ажиллаж л дээ
- Continuous /үргэлжлэх/ бүлэгт хувирдаггүй үгсийг бид дээр үзсэн билээ.
Үүнтэй мөн адилаар тэдгээр үгс нь Perfect Continuous /төгсөн үргэлжлэх/
бүлэгт хувирдаггүй бөгөөд тухайн санааг Perfect /төгсөх/ цагийн бүлэгт
хувиргаж илэрхийлнэ.
I have known Tom since 1992-Би Томыг 1992 оноос хойш мэдэх юм.
- Нэг үйл явдал болж өнгөрснөөс хойш үргэлжилж буй үйл явдлыг
илэрхийлнэ. Дүрэм ёсоор цаг заасан гишүүн өгүүлбэр бүхий угсарсан
нийлмэл өгүүлбэр хэрэглэгдэх бөгөөд гол өгүүлбэр нь одоо төгсөн
үргэлжлэх цагт гишүүн өгүүлбэр нь жирийн өнгөрсөн цагт байна.
I have been working here since I graduated from the institute-Би дээд сургууль
төгссөнөөсөө хойш энд ажиллаж байна.

Тусгай асуулт

How long have you been learning English?-Чи англи хэлийг хэр удаан үзэж байна вэ?

Ерөнхий асуулт

Have you been waiting for me for a long time?-Чи намайг удаан хүлээв үү?

Yes, I have. –Тийм ээ

Үгүйсгэх өгүүлбэр

(Энэ цагт үгүйсгэх өгүүлбэр нэг их хэрэглэгддэггүй)

He hasn't waiting for Tom. He has been waiting for John-Тэр Томыг хүлээсээр байгаа юм биш, тэр Жоныг хүлээгээд байгаа юм.

Өнгөрөн төгсөн үргэлжлэх цаг

The Past Perfect Continuous Tense

Энэ цагийг томъёолбол:

Had been+ P1

Энэ цагийг доорх тохиолдолд хэрэглэнэ.

- Тодорхой нэг цаг хугацаа хүртэл үйл явдал хэдий хэр хугацаанд үргэлжлээд байсан болохыг илэрхийлнэ.

They had been working in the garden for an hour by 4 o'clock-Тэд 4 цаг гэхэд ногооны талбайд нэг цагийн турш ажиллаад байсан.

Энэ өгүүлбэрийн “for” угтварыг “since” угтвараар сольж хэдийнээс хойш ажилласаар байсан болохыг илэрхийлж болно.

They had been working here for 5 years by 1997-Тэд энд 1997 он гэхэд 5 жил ажиллаад байсан.

- Нэг үйл явдал болж өнгөрөхөд түүнээс өмнө өөр нэг үйл явдал хэдий хэр хугацаанд үргэлжлээд байсан болохыг илэрхийлнэ. Энэ тохиолдолд цаг гишүүн өгүүлбэр бүхий угсарсан нийлмэл өгүүлбэр хэрэглэгдэх бөгөөд гишүүн өгүүлбэр нь жирийн өнгөрсөн цагт байна.

We had been playing football for about 20 minutes when it began to rain-Бороо орж эхлэх үед бид 20 минут орчим хөлбөмбөг тоглосон байсан.

- Дээрх 2 тохиолдлыг харахад

а/ Нэг үйл явдал тодорхой нэг хугацаа эсвэл өөр нэг үйл явдал хүртэл үргэлжлээд дууссан.

He had been working in the laundry for hours, so he didn't do anything in the afternoon-Тэр угаалгын газар хэдэн цагийн турш ажилласан болохоор үдээс хойш юу ч хийсэнгүй.

б/ Эсвэл цаашид ч бас үргэлжилсээр байх санаа илэрхийлнэ. Тэрчлэн нэг үйл явдал өөр нэг үйл явдал болохын өмнө дуусаад байсан болохыг илэрхийлнэ.

I had been studying and decided to take a stroll to clear my mind-Би нэлээд хичээллэсэн байсан болохоор толгойгоо сэргээхийн тулд салхинд гарахаар шийдсэн билээ.

- Үйл явдал дахин давтагдсаар байж болохыг илэрхийлж болно.

He had been trying to telephone her mother all day-Тэр ээжтэйгээ утсаар ярих гэж өдөржингөө оролджээ.

- Дам үгэнд өнгөрөн үргэлжилсэн ба одоо төгсөн үргэлжлэх цагт буй шууд үгийг өнгөрөн төгссөн үргэлжлэх цагт шилжүүлж хэлдэг.

Tom said that he been holding ladder for half an hour-Би энэ шатыг хагас цаг барьж байна гэж Том хэлэв.

Асуух өгүүлбэр

Өнгөрөн төгссөн үргэлжлэх цаг нь асуух өгүүлбэрт тэр болгон хэрэглэгддэггүй. How long? Гэсэн асуулт гол төлөв хэрэглэгдэнэ.

How long had been you planting trees when Erdene came?-Эрдэнийг очиход мод аль хэр удаан суулгаад байсан бэ?

Who had been asking me all morning?-Хэн намайг өглөөжингөө асуугаад байсан бэ?

Ирээдүйд төгсөн үргэлжлэх цаг

The Future Perfect Continuous Tense

Энэ цагийг томъёолбол

Shall
Have+been+PI
Will

Энэ цагийг доорх тохиолдолд хэрэглэнэ.

- Ирээдүйд тодорхой нэг цаг хугацаа(Өдөр, сар, жил) гэхэд тухайн үйл явдал хэдий хэр хугацаанд үргэлжлээд байхыг илэрхийлнэ.

The competition will have been lasting for 2 hours by 7 o'clock-7 цаг гэхэд тэмцээн 2 цаг үргэлжлээд байх болно.

- Ирээдүйд нэг үйл явдал болоход түүнээс өмнө өөр нэг явдал хэдий хэр хугацаанд үргэлжлээд байхыг илэрхийлнэ.

I shall have been working for 3 years when my younger sister enters school-Дүү охиноо сургуульд орох үед би 3 жил ажил хийгээд байх болно.

Дээрх тохиолдолд цаг заасан гишүүн байц гишүүн өгүүлбэр

бүхий угсарсан нийлмэл өгүүлбэр хэрэглэгдэж байгаа бөгөөд гишүүн өгүүлбэр нь жирийн одоо цагт байна. Мөн үүнээс гадна нөхцөл заасан байц гишүүн өгүүлбэр бүхий угсарсан нийлмэл өгүүлбэр хэрэглэгдэж болно.

If you come back from Seoul in august, I shall have been working in the Recreation Centre for 2 months-Хэрэв чи Сөүлээс 8 сард эргээд ирвэл би Соёл амралтын хүрээлэнд 2 сар ажиллаад байх юм байна.

Асуух өгүүлбэр

How long will you have been living in Ulaanbaatar by 2002?-Чи 2002 он гэхэд Улаанбаатарт хэр удаан амьдраад байх вэ?

Үгүйсгэх өгүүлбэр

I shall not have been waiting for him until he comes-Би түүнийг иртэл нь хүлээсээр байх юм биш.

Өнгөрсөн цагийн өнгөнөөс эс

тухайлах ирээдүй цаг

The Future Indefinite in the Past Tense

Энэ цагийг томъёолбол

should
Гол өгүүлбэр+ +үйл үг
would

Энэ цагийг доорх тохиолдолд хэрэглэнэ.

- Эс тухайлах ирээдүй цагт буй шууд хэлсэн үгийг дам болгож дамжуулахдаа гол өгүүлбэрийн өгүүлэхүүнийг өнгөрсөн цагаар илэрхийлбэл гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүнийг өнгөрсөн цагт буюу тодруулбал өнгөрсний ирээдүй цагт шилжүүлнэ.

John said: "My brother will buy a car" – "Миний ах машин худалдаж авна" гэж Жон хэлэв.

John said that his brother would buy a car-Ах нь машин худалдаж авна гэж Жон ярьсан

- Ирээдүйд ямар нэгэн үйл явдал болохыг мэдэж байсан тухайд хожим өгүүлэхэд хэрэглэнэ.

We hoped that he would devote his life to art-Түүнийг урлагт амьдралаа зориулна гэж бид найдаж байсан.

- Хүссэн бодсон санаагаа илэрхийлж болно. Хэрвээ болж өнгөрсөн цаг хугацаа тодорхойгүй байвал дараах өөрчлөлт гарна. Үүнд:

This-that

These-those

Tomorrow-the following/next day

The day after tomorrow-in two day's time гэх мэтчилэн

We expected that he would phone in two day's time-Түүнийг нөгөөдөр нь утасдана гэж бид хүлээж байсан

Үгүйсгэх өгүүлбэр

I didn't know that you wouldn't come to the party-Би чамайг үдэшлэгт ирэхгүй гэдгийг мэдээгүй байсан.

Өнгөрсөн цагийн өнгөнөөс ирээдүйд

Үргэлжлэх цаг

The Future Continuous in the Past Tense

Энэ цагийг томъёолбол:

Should
Be+PI
Would

Жишээ нь:

Bayar said:"I shall be doing my homework at 8 o'clock this evening"=Bayar said that he would be doing his homework at 8 o'clock that evening-Өнөө орой 8 цагт гэрийн даалгавраа хийж байх болно гэж Баяр ярьсан.

Асуух өгүүлбэр(дам):

My friend asked me:"What will you be doing at this time tomorrow ?"=My friend asked me what I would be doing at that time the following day-Маргааш өдийд юу хийж байхыг минь найз минь надаас асууж байсан

Үгүйсгэх өгүүлбэр:

I thought that you wouldn't be playing football with the little children-Би чамайг жаахан хүүхдүүдтэй хөл бөмбөг тоглоод байж байх юм гэж бодоогүй.

Өнгөрсөн цагийн өнгөнөөс ирээдүйд төгсөн цаг

The Future Perfect in the Past

Энэ цагийг томъёолбол:

Should
Have+PII
would

Жишээ нь:

They thought that they would have finished the work by 6 o'clock- Тэд ажлаа 6 цаг гэхэд дуусчихна гэж бодоцгоож байжээ.

Асуух өгүүлбэр

The teacher asked us by what time we should have cleaned the classroom-барш биднээс хэдэн цаг гэхэд ангиа цэвэрлэхсэн байхыг асууж байсан.

Үгүйсгэх өгүүлбэр

They thought that she wouldn't have left before they came- Тэд тэр эмэгтэйг очихоос нь өмнө явахгүй гэж бодоцгоож байжээ.

Өнгөрсөн цагийн өнгөнөөс ирээдүйд төгсөн үргэлжлэх цаг

The Future Perfect Continuous in the Past

Энэ цагийг томъёолбол:

Should
Have+been+PI
would

Жишээ нь:

The engineer Suren said that he would have been working at the factory for ten years by 1997-Инженер Сүрэн 1997 он гэхэд үйлдвэртээ 10 жил ажиллаад байх юм байна гэж ярьж байсан.

Асуух өгүүлбэр

My sister asked father how long we should have been living in the apartment by 2000-Эгч ааваас 2000 он гэхэд энэ байранд бид хэчнээн жил амьдраад байхыг асууж байв.

She inquired if she would have been waiting for half an an hour when the meal was ready-Хоол бэлэн болтол хагас цаг хүлээхүү гэж тэр эмэгтэй лавлаж асуув.

Үгүйсгэх өгүүлбэр

The company director thought that he wouldn't have been waitingso long to receive the reply to his fax- Компанийн захирал цахилгаан шуудангийнхаа хариуг автал нэг их удаан хүлээхгүй гэж бодож байжээ.

Үйл үгийн цаг - Tenses of verbs

Үйл үгийн энэ цаг нь утгаараа өгүүлэгч этгээдийн ярьж буй үе ба үйл явдал хоёрын хоорондын холбоо харилцааг илэрхийлэх хэл зүйн ойлголт юм.

Орчин үеийн ангил хэлэнд үйл үгнийн 26- н цаг байдгаас 16- нь өөрөө үйлдэх буюу идэвхитэй хэвийн , 10-цаг нь бусдын эрхэнд үйлдэх буюу идэвхигүй хэвийг заадаг.

Эдгээр цаг нь

- 1, Одоо (present)
2. Өнгөрсөн (past)
3. Ирээдүй (future)

гэсэн үндсэн гурван цаг суурилна. Одоо цаг нь үйл явдал үйл этгээдийн яриж буй үйлдэлтэй давхцаж буйг илэрхийлнэ. Өнгөрсөн цаг нь үйл явдал өгүүлэгч этгээдийн яриж буй үеэс өмнө болж өнгөрсөнийг илэрхийлнэ. Ирээдүй цаг нь үйл явдал өгүүлэгч этгээдийн яриж буй үеэс хойших болохыг илэрхийлнэ. Англи хэлэнд үндсэн 3 төрлийн асуух өгүүлбэр байдаг.

- 1, Тусгай асуулт (special question)

Асуух үг + туслах үйл үг + өгүүлэгдэхүүн + өгүүлэхүүн + тусагдахуун + байц

Жишээ нь : What time do you go to school ?

2. Ерөнхий асуулт (General question)

Туслах үйл үг + өгүүлэгдэхүүн + өгүүлэхүүн + тусагдахуун + байц

Ерөнхий асуулт нь yes , no гэсэн хариултын алт нэгийн шаардана.

Жишээ нь : Do you learn English? Yes I do ,

3. Ялгах асуулт (Disjunctive question)

Хоёр юмны аль нь болохыг мэдэх зорилгоор ялгах асуулт тавина. Холбоос нь нь “ or ” юм.

1, Туслах үг+ өгүүлэгдэхүүн or өгүүлэхүүн+өгүүлэгдэхүүн+тусагдахуун + байц

Жишээ нь : Do you or do the clean these rooms on sunday? We do

2, Туслах үг + өгүүлэгдэхүүн + өгүүлэхүүн + or + тусагдахуун + байц

Жишээ нь : Do you work or study? I study

3, Туслах үг + өгүүлэгдэхүүн + өгүүлэхүүн + тусагдахуун + or + тусагдахуун + байц

Жишээ нь : Do you learn English or German ? I learn English

4. Туслах үг + өгүүлэгдэхүүн + өгүүлэхүүн+тусагдахуун + байц + or + байц

Жишээ нь : Do you go to school in the morning or in the afternoon.

I go to school in the afternoon.

5, “ or ” холбоос тодотгол гишүүний хооронд байж болно.

Жишээ нь : Do you read English or Russian newspaper ? I read Russian

Идэвхитэй хэв Active Voice

Жирийн одоо цаг Present indefinite ten

Жирийн одоо цагт үйл үг I , you , we, they гэсэн биеүүдэд үйл үгийн үндэстэй тохирно. Жишээ нь : I go to school.

He , she , it гэсэн биетүүдэд үйл үгийн үндсэнд -s , -es гэсэн төгсгөл залгаж жирийн одоо цагийг үүсгэнэ. Жишээ нь : She does to school.

Баталсан өгүүлбэрт :

өгүүлэгдэхүүн (i , you , we)+ үйл үг

өгүүлэгдэхүн (he , she , it)+үйл үг + es ,s

Асуух хэлбэрт :

туслах үйл үг (do)+ үйл үг Өгүүлэгдэхүүн (i , you , we)+ үйл үг Туслах үйл үг
(does)+үйл үг + es ,s Өгүүлэгдэхүн (he , she , it)+
+үйл үг

үгүйсгэх Өгүүлбэрт :

Өгүүлэгдэхүүн (i , you , we)+ туслах үйл үг +not+ үйл үг

Өгүүлэгдэхүн (he , she , it)+туслах үйл үг(does)+not + үйл үг

Жишээ нь : I live a country.

I don't live country

Do you live country?

Жишээ нь : She lives country.

She dosn't live country

Does she live country?

He ,she , it гэсэн гурван биеэс Жирийн одоо цаг үүсгэхэд доорх бичлэгийн дүрмийг баримтална.

1, -s төгсгөлийг

а) эгшигээр төгссөн үгэнд залгана. Жишээ нь : take- takes

Хэрэв “ y ” –ийн өмнө гийгүүлэгч байвал “ y ” нь “ l ” болж хувирах ба “ -es ” төгсгөл залгана. Жишээ нь : study-studies

б) Гийгүүлэгчээр төгссөн үгэнд залгана. Жишээ нь : work-works

2. –es төгсгөлийг дараах төгсгөлтэй үгэнд залана.

-ss: drees-dreesses

-sh: rush-rushes

-ch: teach-teaches

-tch: watch-watches

-x: tax-taxes

-o: go-goes

Жирийн одоо цаг доорх тохиолдолд хэрэглэгддэг.

1, байнгын шинжийг илэрхийлнэ.

Жишээ нь : The bird flies - шувуу бол нисдэг.

2, одоо цагт байнга давтагдаж байдаг үйл явдлыг илэрхийлнэ. Монгол хэлнээ гол төлөв – даг , дэг , дог , дуг төгсгөлд нь залгаж орчуулна.

Жишээ нь : I go to school by bus - би сургуульруугаа автобусаар явдаг.

3, Ямар нэгэн хөтөлбөр , цагийн хуваарийн тухай өгүүлэхэд ирээдүй цагийн утгаар илэрхийлнэ.

Жишээ нь :What time does the concept begin? Консепт хэдэн цагт эхлэх вэ?

4,Уран зохиолд болж өнгөрч буй үйл явдлыг тайлбарлан өгүүлэхэд

5, Цаг заасан байц гишүүн өгүүлбэр бүхий угсарсан нийлмэл өгүүлбэрийн гишүүн өгүүлбэрт хэрэглэнэ.

Жишээ нь :I'll go home when he returns.Түүнийг ирэхээр би гэрлүүгээ явна.

6, Нөхцөл заасан байц гишүүн өгүүлбэрт хэрэглэнэ.

Жишээ нь :If he lends me some money, I'll buy this CD player

Хэрэв том надад мөнгө зээлүүлбэл би энэ CD тоглуулагчийг худалдаж авна.

Жирийн одоо цагт дараах үйл хавсрал хэрэглэгдэнэ.

Always – ямагт дандаа I always play chess

Usually – ихэвчлэн She usually comes home at 6 o'clock

Often - голдуу He often stays home

Sometimes – заримдаа He sometimes sit sat the library

Seldom – хааяа We seldom miss classes

Rarely – ховорхон I rarely watch TV

Occasionally - үе үе I occasionally play eart

Never – хэзээ ч I never a smoke

Тусгай асуулт : Where doer your father work?

My father works in office

Who lives in the center of the city?

Bat lives in the center of the city

When do you go to school?

I go to school everyday

Ерөнхий асуулт : Do you do your home work in the evening?

No, I don't

Does your sister study at the University of the UB?

Yes , She does

Ялгах асуулт: Does your father or sisiter learn English?

My brother learns English

Do you do many or few exercises at the lesson?

We do many exercises at he lesson.

Жирийн өнгөрсөн цаг The past Indefine tense

1, Үйл үгийн үндсэн d , ed төгсгөл залгаж , аль эсвэл үйл үг хувирч жирийн өнгөрсөн цагийг үүснэнэ. Үйл үгийн үндсэнд -ed төгсгөл залгаж жирийн

өнгөрсөн цаг үүсгэхэд доорх дүрмийг баримтална. Хэрэв үйл үг “ e ” эгшигээр төгссөн байвал “ ed ” төгсгөл залгахад “ e ” гээгдэнэ.

Жишээ нь : to like + ed = liked

2, Үгийн эцсийн “ y ” –ийн өмнө гийгүүлэгч байвал “ y ” нь “ i ” болж хувирна.

Жишээ нь : to study + ed = studied

3. Үгийн эцсийн дан гийгүүлэгч нь өмнө богино эгшиг байвал эцсийн гийгүүлэгчийг давхарлаж бичнэ.

Жишээ нь : to drop + ed = dropped

4, Бусад тохиолдолд -ed төгсгөлийн үйл үг энд шууд бичнэ.

Жишээ нь : to answer + ed = answered

Зөв биш үйл үгээс жирийн өнгөрсөн цаг хэд хэдэн янзаар үүснэ.

1, Үндэс өөрчлөгдсөн үүсдэг үйл үгс:

Жишээ нь : know – know , drink - drank

2.Эцсгийн гийгүүлэгч нь солигддог үйл үгс:

Жишээ нь : build – built , lend – lent

3, “ t ” төгсгөл залгаж үүсдэг үйл үгс:

Жишээ нь : burn – burnt , smell – smelt

4, Өөрчлөгддөггүй хэвээр бичдэг үйл үгс:

Жишээ нь : let – let , set – set

5, Үндсэн давхцдаг үйл үгс:

Жишээ нь : be – was , were - been

Жирийн өнгөрсөн цагийн томъёо нь :

Баталсан өгүүлбэрт :

өгүүлэгдэхүүн + өгүүлэхүүн = (Дүрэм , дүрэм бус)+ тусагдахуун + байц

Үгүйсгэсэн өгүүлбэрт :

өгүүлэгдэхүүн + туслах үйл үг (did)+ not + өгүүлэхүүн

Асуух өгүүлбэрт:

Туслах үйл үг (did)+ өгүүлэгдэхүүн + өгүүлэхүүн

Жишээ нь : I dot up at 6o'clock this mornung.

I didn't get up at 6 o'clock this morning.

Did you get up at 6 o'clock this morning?

She learned English last year

Did she learn English last year?

Жирийн өнгөрсөн цаг дараах тохиолдолд хэрэглэгдэнэ.

1, Нэг удаа болоод өнгөрсөн үйл явдлыг илэрхийлнэ. Монгол хэлнээ ихэвчлэн - сан , сэн сон сун төгсгөл залгаж оруулна.

Жишээ нь : They moved to Australia last year.

Өнгөрсөн жил тэд Австрали руу нүүсэн.

2, Хэд хэдэн үйл явдал дараалан болж өнгөрөхөд:

Жишээ нь : He entered the room , opened the window and satdown on sofa.

Тэр өрөөнд орж цонх нээгээд буйдан дээр суув.

3, Өнгөрсөн цагт давтагдаж байсан үйл явдлыг илэрхийлнэ. Монгол хэлнээ -даг , дэг , дог, дуг байсан , байв , байлаа , гэх мэтээр орчуулагдана.

Жишээ нь : When I was a child , I went to the kindergarden.

Би хүүхэд байхдаа цэцэрлэгт явдаг байв.

4, Цаг заасан байц гийшүүн өгүүлбэр бүхий угсарсан нийлмэл өгүүлбэрийн гишүүн өгүүлбэрт хэрэглэнэ.

Жишээ нь : when I got there ,all the people had gone.

Намайг тэнд хүрч очиход бүх хүмүүс явчихсан байлаа.

5.Хүссэн болзох төлөвт буй ХНӨ -ийн гишүүн өгүүлбэрт хэрэглэнэ.

Жишээ нь : If I worked iwould have more money.

Хэрэв би ажил хийдэгсэн бол арай илүү мөнгөтэй байхсан.

6. “ It is time someone did something ” гэсэн хэллэгт хэрэглэнэ.

Жишээ нь : It is time we home.

Бид гэртээ харих цаг болж.

7. Шууд хэлсэн үгийг хожим дам болгон ярихдаа шууд үг нь жирийн одоо цагт байсан бол дам үг болгохдоо жирийн өнгөрсөн цагийг хэрэглэнэ.

Жишээ нь : That girl told me she lived with her grandmather.

Тэр охин эмээтэйгээ амьдардаг гэж надад ярьсан.

Энэ цагт хэрэглэгдэх цаг заасан дайвар үг .

Yesterday - өчигдөр I went to country yesterday the day before yesterday -
уржигдар

They read interesting book the day before yesterday.

Last week (month , year) - өнгөрсөн долоо хоног

I went to Japan last week

Last time – сүүлчийн удаа

I sent letter my friend last time.

Ago - Өмнө I met my friend ago five.

Тусгай асуулт :

Жишээ нь : What time did you go to bed last night?

I went to bed last night at 12 pm.

Ерөнхий асуулт:

Жишээ нь : Did you dance at the party yesterday ?

Yes . I do .

Ялгах асуулт:

Жишээ нь : Did you receive your parcel or your letter this morning?

I received my parcel.

Хоёр үйл үг нэг дор орвол “ to ” гэсэн дагавараар холбоно.

Жишээ нь : She took a book , opened it and began to read.

Тэр эмэгтэй ном аваад нээн уншиж эхлэв.

Хэрэв асуух агүүлбэрт үгүйсгэсэн байвал :

Why didn't you know this grammar rule yesterday?

Өчигдөр чи энэ дүрмийг яагаад мэдээгүй вэ?

Хэрэв ийм өгүүлбэр ерөнхий асуулт байвал өгүүлэгч этгээдийн гайхсан байдлыг илэрхийлнэ. Don't you know this grammar rule ?

Чи энэ дүрмийг мэддэггүй гэж үү?

Жирийн Ирээдүй Цаг
The Future Indefinite Tense

Жирийн ирээдүй цагийг үйл үгийн өмнө “shall”, “will” туслах үйл үгсийг залгаж үүсгэнэ. I биеийн ганц ба олон тоонд “shall” бусад тохиолдолд “will” туслах үйл үгийг хэрэглэнэ. Жирийн ирээдүй цаг доорхи тохиолдолд хэрэглэгдэнэ.

1. Ирээдүйд нэг удаа болж өнгөрөх үйл явдлыг илэрхийлэхэд (монгол хэлнээ ихэвчлэн –на⁴, -х болно хэмээ орчуулагддаг):

Tomorrow we shall visit the Museum of Natural History.

Маргааш бид Байгалийн түүхийн мүзей үзнэ.

2. Ирээдүйд давтагдах үйл явдлыг болон байнгын шинжийг илэрхийлнэ.

Erdene will go in for free style wrestling every Wednesday.

Эрдэнэ лхагва гариг бүр чөлөөт бөхөөр хичээллэж байх болно.

3. Ирээдүйд дараалан болох үйл явдлыг тоочиход дараах байдалтай байна:

I'll go home, take my cassette player and come back.

Би гэртээ харьж магнитофоноо аваад, эргэж ирнэ.

Үгүйсгэх өгүүлбэр:

She won't go to work tomorrow.

Тэр эмэгтэй маргааш ажилдаа чвахгүй.

Тусгай асуулт:

When will your brother graduate from the Institute?

Танай ах чинь дээд сургуулиа хэзээ төгсөх вэ?

Ерөнхий асуулт:

-Will you write a diploma paper next year? -Чи ирэх жил дипломын ажил бичих үү?

-Yes, I shall. –Тийм ээ.

Ялгах асуулт:

Will he go to the evening course or the extramural course?

Тэр оройн ангид суралцах уу, эчнээ ангид суралцах уу?

Category Ай	Indicative Mood Цаг заах төлөв			
	Active Voice Идэвхтэй цаг			
	Non-perfect correlation Эс төгсөх харьцаа		Perfect correlation Төгс харьцаа	
	Common aspect Ерөнхий байдал	Continuous aspect Үргэлжлэх байдал	Common aspect Ерөнхий байдал	Continuous aspect Үргэлжлэх байдал
	Indefinite Жирийн	Continuous Үргэлжлэх	Perfect Төгссөн	Perfect continuous Төгсөн үргэлжлэх
Present Одоо	Жирийн одоо цаг /эс тухайлах одоо цаг/	Одоо үргэлжлэх цаг	Одоо төгссөн цаг	Одоо төгсөн үргэлжлэх цаг
Past өнгөрсөн	Жирийн өнгөрсөн	Үргэлжлэн өнгөрсөн цаг	Өнгөрөн төгссөн цаг	Өнгөрөн төгсөн үргэлжлэх цаг
Future Ирээдүй	Жирийн ирээдүй	Ирээдүйд үргэлжлэх цаг	Ирээдүйд төгсөх цаг	Ирээдүйд төгсөн үргэлжлэх цаг
Future in the past Өнгөрсний ирээдүй	Өнгөрсөн цагийн өнгөнөөс эс тухайлах ирээдүй цаг	Өнгөрсөн цагийн өнгөнөөс ирээдүйдээ үргэлжлэх цаг	Өнгөрсөн цагийн өнгөнөөс ирээдүйдээ төгсөх цаг	Өнгөрсөн цагийн өнгөнөөс ирээдүйдээ төгсөн үргэлжлэх цаг